



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,  
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,  
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,  
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.05.16 № 01/906  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Тендерийн баримт бичиг  
хянасан тухай**

Танай нийгэмлэгээс зарласан “APC-4 төрлийн зам төмрийн бэхэлгээний бетон дэрний анкер” МЗХННУБТЗ/20240102020 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Хазаарбат” ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-т “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай” 2022, 2023 оны аль нэг жилд нийлбэр дүнгээрээ батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн [50] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг нийлүүлсэн байх шаардлагатай. /Тухайн жилүүдийн аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээнүүдийн нийлбэр дүн нь заасан хувиас багагүй” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой...хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж, 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэлсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.” гэж, 17 дугаар зүйлийн 17.1-д “Захиалагч техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг оролцогчоос шаардаж болно.” гэж, 17.2.2-т “бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтын хувьд сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд нийлүүлсэн бараа, үзүүлсэн үйлчилгээний жагсаалт, тэдгээрээс ижил төстэй бараа, үйлчилгээний өртөг, хугацаа, байршил, гэрээний үүргийг гүйцэтгэсэн болохыг нотлох баримт;” гэж тус заасан байна.

Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “2022, 2023 оны аль нэг жилд...нийлүүлсэн байх шаардлагатай.” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь хэсэгт заасны дагуу боловсруулсан байна.

Харин “APC-4 төрлийн зам төмрийн бэхэлгээний бетон дэрний анкер” МЗХННУБТЗ/20240102020 дугаартай тендерийн ажил гүйцэтгэх нийт төсөвт өртөг 4,889,248,000 төгрөг бөгөөд тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д “төсөвт өртгийн үнийн дүнгийн [50] хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг” гэж заасан нь

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан санхүүгийн зохих доод шаардлагад үндэслэн заагаагүй байна. Мөн тухайн тендер шалгаруулалтад оролцогчдын өрсөлдөөнийг хязгаарласан буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Тендерийн баримт бичгийн бараа нийлүүлэлтийн хуваарьт бараа хүлээн авах эцсийн хугацааг “Гэрээ байгуулснаас хойш 20-60 хоног” гэж заасан байна. Захиалагчаас 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 16/1832 тоот албан бичгээр ирүүлсэн тайлбарт 60 хоногт тухайн бараа материалыг бүрэн нийлүүлэх боломжтой гэж үзсэн ба өмнөх 2022, 2023 онуудад нийлүүлж байсан компаниуд 30 хоногийн дотор бараа материалыг бүрэн нийлүүлж байсан гэж дурдсан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн “Бараа нийлүүлэлтийн хуваарь”-ийг боловсруулахдаа Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/258 дугаар тушаалаар баталсан “Бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-т нийцүүлэн боловсруулсан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-т холбогдох өөрчлөлт оруулан, хэрхэн шийдвэрлэсэн талаар эргэж мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулна уу.

